


Сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын
26 ний өдрийн А/103 тоот захирамжын хавсралт



**Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын
“Шилдэг төрийн албан хаагч” шалгаруулж,
урамшуулах журам**

Нэг: Зорилго

- 1.1. Энэхүү журмын зорилго нь сумын үйлчлүүлэгчдэд хүргэх төрийн үйлчилгээг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхэд бүтээлч санаачлага гарган ажлын арга туршлага бий болгож, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг урамшуулах, шилдэг арга, туршлагыг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоход оршино.

Хоёр: Нийтлэг үндэслэл

- 2.1. Энэхүү журам нь төрийн байгууллагуудад тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн албан хаагчдад хамаарна.
- 2.2. Жил бүр нэг “Шилдэг төрийн албан хаагч”-ийг шалгаруулах ба төрийн албан хаагч нь орон нутагтаа сүүлийн 2-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байна.

***Гурав: Сумын “Шилдэг төрийн албан хаагч”-д
тавигдах шалгуур үзүүлэлт***

- 3.1. Үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ сүүлийн 1 жилд 90-ээс дээш хувиар биелүүлсэн байх.
- 3.2. Хариуцсан ажлын хүрээнд үйлчлүүлэгчдэдээ хүрч үйлчилсэн нь үр дүнгээ өгч, иргэд үйлчлүүлэгчдэд хүлээн зөвшөөрөгдсөн байх.